



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/80/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Л.Мөнхцацрал
Утас: 261740 Цахим хаяг: munkhtsatsrall@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк ОМ Аудит ХХК
Захирал: Б.Жаргалсайхан
Цахим хаяг: peakomaudit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	12
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	12
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	12
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
5.1 Шилэн дансны мэдээлэл	16
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
8. Аудитын илрүүлэлт	16
8.1 Залруулсан алдаа.....	17
8.3 Албан шаардлага.....	17
8.4 Зөвлөмж	18
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨА	Төрийн өмчийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ О.НАРАНДЭЛГЭР ТАНАА

2022.03.15 № 07/535
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 859.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1, Захиргааны Ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2, нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 6,320.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,899.9 сая төгрөг буюу 42 хувиар нэмэгдсэн нь дэлхийн зах зээлд түүхий эдийн үнэ өссөн нь нөлөөлсөн байна.

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Тайлант онд тус хороо нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3 дахь заалтыг хэрэгжүүлэлгүй 3 орон тоог нэмэгдүүлж ажилласан байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Д.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	291,696,602.45	1,808,641,648.24
1.1.2	Дансны авлага	641,845,455.11	2,174,533,355.87
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	42,166,603.08	84,569,031.76
1.1.4	Бусад авлага	10,136,061.00	16,708,244.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	9,264,751.98	14,828,311.76
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,492,634,198.63	164,482,624.82
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,487,743,672.25	4,263,763,216.45
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,664,014,003.29	2,007,256,728.22
1.2.2	Биет бус хөрөнгө	87,997,582.11	1,705,144,803.69
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,752,011,585.40	3,712,401,531.91
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,239,755,257.65	7,976,164,748.36
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	85,020,220.19	174,346,893.91
2.1.1.2	Цалингийн өглөг	1,612,317.25	
2.1.1.3	Татварын өр	25,493,458.29	451,061,217.55
2.1.1.4	НДШ-ийн өглөг	21,838.13	
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	543,273,154.87	
2.1.1.12	Бусад богино хугацаат өр төлбөр	5,400,000.00	900,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	660,820,988.73	626,308,111.46
2.2	Өр төлбөрийн нийт дүн	660,820,988.73	626,308,111.46
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: -төрийн	1,021,700,000.00	1,021,700,000.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	10,000.00	10,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,557,224,268.92	6,328,146,636.90
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,578,934,268.92	7,349,856,636.90
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,239,755,257.65	7,976,164,748.36

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	319,986,786.12	6,320,072,229.50
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	319,986,786.12	6,320,072,229.50
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	38,210,816.52	274,387.98
8	Бусад орлого		80,000,000.00
9	Борлуулалт маркетингийн зардал	37,880,164.43	59,314,865.27
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,585,410,993.23	2,012,154,584.67
12	Бусад зардал	19,744,850.82	125,648,406.15
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	56,285.63	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,284,782,120.21)	4,203,228,761.39
19	Орлогын татварын зардал	3,821,081.64	432,328,244.69
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,288,603,201.85)	3,770,900,516.70
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,288,603,201.85)	3,770,900,516.70
24	Орлогын нийт дүн	(1,288,603,201.85)	3,770,900,516.70
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон**/төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,021,700,000.00	10,000.00	4,403,847,016.11	5,425,557,016.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга			(14,746,390.47)	(14,746,390.47)
Залруулсан үлдэгдэл	1,021,700,000.00	10,000.00	4,389,100,625.64	5,410,810,625.64
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			1,288,603,201.85	1,288,603,201.85
Зарласан ногдол ашиг			(543,273,154.87)	(543,273,154.87)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,021,700,000.00	10,000.00	2,557,224,268.92	3,578,934,268.92
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга			(21,851.28)	(21,851.28)
Залруулсан үлдэгдэл	1,021,700,000.00	10,000.00	2,557,246,120.20	3,578,956,120.20
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			3,770,900,516.70	3,770,900,516.70
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,021,700,000.00	10,000.00	6,328,146,636.90	7,349,856,636.90

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	337,854,528,812.63	227,251,165,962.85
	Бараа борлуулсан. үйлчилгээ үзүүлсний орлого	828,165,961.28	5,409,081,224.94
	Бусад мөнгөн орлого	337,026,362,851.35	221,842,084,737.91
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	339,904,452,551.99	224,073,827,159.44
	Ажиллагчдад төлсөн	731,599,736.55	939,776,788.25
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	230,482,385.52	291,896,335.93
	Бараа материал худалдан авахад төлсөн	24,561,567.67	32,571,639.05
	Ашиглалтын зардалд төлсөн	105,124,198.19	123,685,543.25
	Түлш. шатахуун. тээврийн хөлс. сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,867,602.23	8,304,390.21
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	222,730,070.32	110 855 910.96
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	338,582,086,991.51	222,566,736,551.79
1.3	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(2,049,923,739.36)	3,177,338,803.41
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	38,210,816.52	274,387.98
	Хүлээн авсан хүүний орлого	38,210,816.52	274,387.98
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,062,760,275.00	1,112,894,990.73
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,046,215,033.00	381,438,490.73
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	16,545,242.00	
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		731,456,500.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(1,024,549,458.48)	(1,112,620,602.75)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан. өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		547,773,154.87
	Зээл. өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцааны мөнгөний буцаалт		4,500,000.00
	Төлсөн ногдол ашиг		543,273,154.87

3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(547,773,154.87)
4	Валютын ханшийн зөрүү	56,285.63	
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(3,074,416,912.21)	1 516 945 045.79
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,366,113,514.66	291,696,602.45
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	291,696,602.45	1,808,641,648.24

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
	а)Арилжааны хэмжээ	тонн	18,981.8	29,000.0	15,119.0	13,881.0	52.1
		ширхэг		300,000.0	30,000.0	270,000.0	10.0
	Ноолуур	тонн	6,944.0	6,000.0	6,085.0	(85.0)	101.4
	Хонины ноос	тонн	4,106.0	9,500.0	5,378.0	4,122.0	56.6
	Тэмээний ноос	тонн	1,316.0	1,500.0	479.0	1,021.0	31.9
	Ямааны завод ноос	тонн	1,737.0	2,500.0	2,326.0	174.0	93.0
	Хонины завод ноос	тонн	509.0	1,500.0	51.0	1,449.0	3.4
	Тосны ургамал	тонн	3,360.0	8,000.00	800.0	200.0	10.0
	Арьс шир /бод/	*ширхэг		300,000.0		300,000.0	
	Арьс шир /ямааны боловсруулсан арьс/	*ширхэг			30,000.0	(30,000.0)	
	б)Арилжааны дүн	мян.төг	488,720,000.0	592,280,000.0	794,561,716.0	(202,281,716.0)	134.1
	Ноолуур	мян.төг	427,170,000.0	480,000,000.0	728,771,167.0	(248,771,167.0)	151.8
	Хонины ноос	мян.төг	9,760,000.0	27,550,000.0	10,661,385.0	16,888,615.0	38.7
	Ямааны завод ноос	мян.төг	37,180,000.0	55,000,000.0	49,730,072.0	5,269,928.0	90.4
	Тэмээний ноос	мян.төг	10,960,000.0	19,200,000.0	4,213,300.0	14,986,700.0	21.9
	Хонины завод ноос	мян.төг	630,000.0	2,400,000.0	105,792.0	2,294,208.0	4.4
	Тосны ургамал	мян.төг	3,020,000.0	7,680,000.0	720,000.0	6,960,000.0	9.4
	Арьс шир	мян.төг		450,000.0		450,000.0	
	Арьс шир /ямааны боловсруулсан арьс/	мян.төг			360,000.0	(360,000.0)	
	2	Нийт орлого	мян.төг	358,197.6	4,500,382.4	6,400,346.6	(1,899,964.3)
3	Нийт зардал	мян.төг	1,642,979.7	2,771,285.7	2,197,117.9	574,167.9	79.3
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	(1,284,782.1)	1,729,096.6	4,203,228.8	(2,474,132.1)	243.1
5	Цэвэр ашиг (алдагдал)	мян.төг	(1,288,603.2)	1,556,186.9	3,770,900.5	(2,214,713.5)	242.3
6	Нийт төсөвт төлөх татвар:	мян.төг	457,033.5	535,999.7	821,698.1	(285,698.4)	153.3
	а) Орлогын татвар	мян.төг	3,821.1	172,909.7	432,328.2	(259,418.6)	250.0
	б) ХХОАТ	мян.төг	222,730.1	85,672.6	97,312.2	(11,639.7)	113.5
	в) ЭМНДШ	мян.төг	230,482.4	277,417.5	292,057.7	(14,640.2)	105.3
7	Нийт ажиллагсдын тоо	мян.төг	43	43	43		100.0
8	Нийт цалингийн сан	мян.төг	1,037,717.4	1,109,670.0	1,101,510.2	8,159.8	99.2
9	Хөрөнгө оруулалт	мян.төг	2,260,408.8	312,591.0	311,675.0	916.0	99.7
10	Нийт авлага	мян.төг	694,148.1	453,875.0	2,174,533,355.9	(2,174,079,480.8)	254.8
11	Нийт өглөг	мян.төг	660,820.9	796,343.6	626,308.1	170 035.5	78.6

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад өглөгийн данс, цахим төлбөрийн баримтын бүрдэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 10-наас 2022 оны 3 дугаар сарын 10-ны хооронд Пийк ОМ Аудит ХХК-ийн ахлах аудитор А.Мөнхцэцэг, аудитор А.Батболд нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Б.Наранчимэг, захирал Б.Жаргалсайхан нар хэрэгжүүлсэн.

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 01/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,643.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 16.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн зорилго нь Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжих тогтолцоог бий болгон хөгжүүлэх замаар малчид, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, замаар үндэсний үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, экспортын орлогыг өсгөх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн спот болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа эрхлэх, хөдөө аж ахуйн гаралтай түүхийн эдийн арилжааг танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулах, хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхийн эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бий болгох, малчид нийлүүлэгчдийг дэмжих гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хязгаарлагдмал хариуцлагатай компани гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 30 дугаар тогтоолыг үндэслэн байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: “... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам томилсон байна.

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 114.4 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд тайлант онд Биржийн Ложистикийн төв болон Блокчэйн системд тулгуурласан арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн системийг төрийн өмчид хүлээн авах, бүртгүүлэхтэй холбоотой ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу гүйцэтгэсэн байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж,

орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх,” гэж заасныг хэрэгжүүлэлгүй 3 орон тоог нэмэгдүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 тоот тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай”

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	291,696.6	1,808,641.6	1,516,945.0
Авлага	694,148.1	2,275,810.6	1,581,662.5
Урьдчилж төлсөн зардал / тооцоо/	1,492,634.2	164,482.6	(1,328,151.6)
Бараа материал	9,264.7	14,828.3	5,563.6
Үндсэн хөрөнгө	1,664,014.0	2,007,256.7	343,242.7
Биет бус хөрөнгө	87,997.6	1,705,144.8	1,617,147.2
Нийт хөрөнгийн дүн	4,239,755.2	7,796,164.7	3,736,409.5
Өр төлбөрийн дүн	660,821.0	626,308.1	(34,512.9)
Эздийн өмч	3,578,934.2	7,349,856.6	3,770,922.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,429,755.2	7,796,164.7	3,736,409.5

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 2.9 сая төгрөг, банк дахь харилцах дансанд 1,805.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,808.6 сая төгрөг болж 1,516.9 сая төгрөгөөр өссөн нь борлуулалтын орлогын өсөлтөөс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 2,395.6 сая төгрөг болж 1,701.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд малчид, бэлтгэн нийлүүлэгчдийг дэмжих зорилгоор малчдад төлөх ноолуурын өрийн үлдэгдлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Наранзолбоот кашмер ХХК-ийн өмнөөс төлж, уг компанитай 2021оны 5 дугаар сарын 21-нээс эхлэн 3 сарын хугацаатай зээлийн гэрээ байгуулсан боловч хугацаандаа төлөөгүйгээс авах авлага 731.4 сая төгрөг, арилжаа төлбөр тооцооны шимтгэлийн авлага 921.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ. Ковид цар тахлын улмаас биржээр арилжсан бараа, түүхий эд хил гаалиар гарч чадаагүйн улмаас авлага өмнөх оноос нэмэгдсэн байна.

Авлагын үлдэгдэлд 1,970.2 сая төгрөгийн авлага хугацаандаа, хугацаа хэтэрсэн 425.4 сая төгрөгийн авлага шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу найдваргүй авлагад нөөц тооцсон байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 164.5 сая төгрөг болж, 1,328.1 сая төгрөгөөр буурсан нь Блокчэйн технологид суурилсан арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн системийн ажлын урьдчилгааг ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 1,508.7 сая төгрөгөөр биет бус хөрөнгөөр бүртгэсэн, тайлант онд Блокчэйн технологид суурилсан

арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн системийн ажлын төлбөрт 180.6 сая төгрөгийг урьдчилж шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 14.8 сая төгрөг болж 5.5 сая төгрөгөөр өссөн нь компанийн хэрэгцээнд шаардлагатай бичиг хэргийн болон хангамжийн материал бэлтгэснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,007.3 сая төгрөг болж, 343.3 сая төгрөгөөр өссөн нь 155.3 сая төгрөгөөр машин тоног төхөөрөмж, 184.9 сая төгрөгөөр компьютер бусад хөрөнгө худалдан авснаас шалтгаалжээ.

Биет бус хөрөнгө данс өмнөх оноос 1,617.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь газар эзэмших, ашиглах эрхийг 80.0 сая төгрөгөөр үнэлж, урьдчилж төлсөн тооцоо дансанд 2019 оноос хуримтлуулан бүртгэсэн 1,568.3 сая төгрөгийн Блокчэйн технологид суурилсан арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн системийг актаар хүлээн авч, программ хангамжийн тайлант оны элэгдлийн зардал 31.2 сая төгрөгийг бүртгэснээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 626.3 сая төгрөг болж, 34.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 432.3 сая төгрөгийн орлогын албан татварын өглөг, ложистикийн төвийн барилга угсралтын ажлын үлдэгдэл төлбөр 76.2 төгрөгийн өглөгөөр нэмэгдэж, 543.3 сая төгрөгийн ногдол ашгийн өглөг, 35.0 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөгийг төлсөнөөс шалтгаалсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 12 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 4,500.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,676.0 сая төгрөгөөр, ашгийг 1,641.9 сая төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 403.6 сая төгрөгийг төлөвлөжээ.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд орлогыг 4,500.4 сая төгрөг, нийт зардлыг 2,578.0 сая төгрөг улмаар 1,730.1 сая төгрөгийн ашигтай байхаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 312.6 сая төгрөгийг тодотгосон байна.

Хүнс, хөдөө ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу хүнсний улаан буудайн арилжааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангахтай холбоотой дотоодын албан томилолтын зардлын төсөвт тодотгол оруулж Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 12 дугаар тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд орлогыг 4,500.4 сая төгрөг, нийт зардлыг 2,771.3 сая төгрөг, 1,729.1 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай байхаар тодотгон баталсан байна.

Гүйцэтгэлээр 6,320.1 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, 80.0 сая төгрөгийн үнэ төлбөргүй орлого, харилцах дансны хүүгийн орлого 0.2 сая төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлж 2,197.1 сая төгрөгийн зардал гаргаж, 4,203.2 сая төгрөгийн ашигтай ажиллаж, 432.3 сая төгрөгийн орлогын татвар төлөхөөр өглөг үүсгэсэн байна.

Хүснэгт 2. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мянган төгрөг/

д/д	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	18,982	29,000	15,119	13,811	52.1
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	358,197.6	4,500,382.4	6,320,146.2	1,819,763.8	140.4
2	Бусад орлого			80,200.0	80,200.0	
3	Хандив тусламж /гадаад/					
	Нийт орлого	358,197.6	4,500,382.4	6,400,346.2	(1,899,964.3)	142.2
4	Үүнээс: Цэвэр борлуулалт	358,197.6	4,500,382.4	6,400,346.2	(1,899,964.3)	142.2
	Нийт зардал	1,642,979.7	2,771,285.7	2,197,117.9	574,167.9	79.2
	Үүнээс:					
5	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг					
6	б) Ерөнхий ба удирдлагын зардал	1,642,979.7	2,458,694.7	1,885,442.9	573,251.9	76.7
7	в) Хөрөнгө оруулалт их засвар		312,591.0	311,675.0	916.0	99.7
	Цэвэр ашиг, алдагдал	(1,288,603.2)	1,556,186.9	3,770,900.5	2,214,7136.6	242.3

Үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 6,320.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,899.9 сая төгрөг буюу 42.2 хувиар нэмэгдсэн нь дэлхийн зах зээлд түүхий эдийн үнэ өссөн нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,197.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 574.2 сая төгрөг буюу 20.8 хувиар дутуу зарцуулсан нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу хэмнэлт гаргаж ажилласантай холбоотой.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн 312.6 сая төгрөгийн ажил хийхээс 311.7 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 3,770.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,214.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь борлуулалтын орлого өсөж, тайлант оны зардлыг хэмнэж ажилласнаас шалтгаалсан байна.

ТӨБЗГ-ын 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 315 дугаар тогтоолын дагуу тайлант онд 543.3 сая төгрөгийн ногдол ашиг буюу цэвэр ашгийн 15 хувийг төвлөрүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь тайлант онд нийт 15,417.3 сая төгрөгийн 163 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 7,514.7 сая төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 833.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 42.3 сая төгрөгийг залруулж, 791.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгснөөс албан шаардлага биелээгүй, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1				1		100.0
Зөвлөмж	2		2				
Нийт дүн	3		2		1		66.6

Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь ил тод, бүрэн мэдээлэх, зөрчлийг арилгах албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй ба хариуцсан албан тушаалтан нь ажлаас чөлөөлөгдсөн тул зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 933.0 сая төгрөгийн 13 алдаа зөрчил илэрснээс, 74.0 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 782.5 сая төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 76.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 859.0 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 16.4 сая төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 74.0 сая төгрөгийн 5 алдааг залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн элэгдүүлэх жил өөрчлөгдсөний улмаас тоног төхөөрөмжийн элэгдлийг байгуулахдаа тооцооллын алдаа гаргаж 17.5 сая төгрөгөөр илүү байгуулсан;
- Санхүүгийн тайланд тусгасан нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн дүн тооцоо нийлсэн актын дүнгээс 0.02 сая төгрөгийн зөрүүтэй;
- 25 нэр төрлийн 1.8 сая төгрөгийн хангамжийн материалыг бөөн дүнгээр, 2 нэр төрлийн 1.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын дансанд тус тус бүртгэсэн;
- ААНОАТ, ХХОАТ-ын авлагыг 8.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан;
- Тайлант онд бэлтгэсэн 45.0 сая төгрөгийн ноос хяргах иж бүрдэл тоног төхөөрөмжийг бусдаар гүйцэтгүүлэх ажил гүйлгээний зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

8.3 Албан шаардлага

1. Гүйцэтгэх захирлын 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн "Албан тушаалын жагсаалт шинэчлэн батлах тухай" А/30 дугаар тушаалаар баталсан орон тооны хязгаараас илүү 3 ажилтантай хөлсөөр ажиллуулах гэрээ байгуулж, 9.6 сая төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант оны байгууллагын худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаагүй 15.3 сая төгрөгийн тавилга хэрэгсэл худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5 "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Шүүхийн шийдвэрийн төлбөр 16.4 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" заалтыг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүйгээр халагдсан ажилтанд олгосон 16.4 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4. Малчид, бэлтгэн нийлүүлэгчдийг дэмжих зорилгоор малчдад төлөх ноолуурын өрийн үлдэгдлийг ТУЗ-ийн шийдвэрээр Наранзолбоот кашмер ХХК-ийн өмнөөс төлж, уг компанитай 2021оны 5 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай зээлийн гэрээ байгуулсан боловч зээлийн төлбөрийг хугацаандаа төлөөгүйгээс 731.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулж, дээрх зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5. Тус компани нь байгууллагын дотоод журмыг зөрчиж, нэр бүхий 4 ажилтанд 9.7 сая төгрөгийн сургалтын төлбөр олгосон нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.19 “Ажилтны орон сууцны судалгааг төрөлжүүлэн гаргаж, түүнд үндэслэн орон сууц, хашаа байшин худалдах авах, шинээр барих, нөхцөлийг нь сайжруулахад хууль тогтоомжийн дагуу банкны урт хугацаат хөнгөлөлттэй зээлд хамруулах, зохих санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх бодлого баримталж, тухайн жилийн төсөвт тусгаж өгнө” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллагын ложистикийн төвийн барилга, угсралтын ажлын үлдэгдэл төлбөр 76.2 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “Ерөнхий нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэгтэй” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах.

2. Анхан шатны баримтын бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд худалдан авсан бараа материалд 0.3 сая төгрөгийн хувь иргэнд олгосон цахим төлбөрийн баримт бүрдүүлсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материал худалдан авах, ажил үйлчилгээний төлбөрийг өөрийн байгууллагын регистрийн дугаараар шивүүлж, худалдан авалт хийсэн байгууллагаас цахим баримтыг гаргуулан авч, баталгаажуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/																
Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Хөдөө аж ахуйн бирж ХХК	АХГ-2022/80/НА-СТА-ТӨА	Машин тоног төхөөрөмжийн элэгдлийг байгуулахдаа тооцооллын алдаа гаргаж илүү байгуулсан.	Аудитын явцад залруулсан	1	17,539.3	1	17,539.3								
2	Хөдөө аж ахуйн бирж ХХК	АХГ-2022/80/НА-СТА-ТӨА	Санхүүгийн тайланд тусгасан нийгмийн даатгалын шийтгэлийн өглөгийн дүн тооцоо нийлсэн актын дүн зөрүүтэй.	Аудитын явцад залруулсан	1	21.8	1	21.8								
3	Хөдөө аж ахуйн бирж ХХК	АХГ-2022/80/НА-СТА-ТӨА	Хангамжийн материалын тайланд 25 нэр төрлийн 1,883.7 мянган төгрөгийн хангамжийн материалыг бөөн дүнгээр, 2 нэр төрлийн 1,299.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын дансанд тус тус бүртгэсэн байна.	Аудитын явцад залруулсан	1	3,183.6	1	3,183.6								
4	Хөдөө аж ахуйн бирж ХХК	АХГ-2022/80/НА-СТА-ТӨА	ААНОАТ, ХХОАТ-ын авлага зөрүүтэй тайлагнагдсан;	Аудитын явцад залруулсан	1	8,291.4	1	8,291.4								
5	Хөдөө аж ахуйн бирж ХХК	АХГ-2022/80/НА-СТА-ТӨА	Тайлант онд бэлтгэсэн ноос хяргах иж бүрдэл тоног төхөөрөмжийг бусдаар гүйцэтгүүлэх ажил гүйлгээний зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.	Аудитын явцад залруулсан	1	45,000.0	1	45,000.0								
6	Хөдөө аж ахуйн бирж ХХК	АХГ-2022/80/НА-СТА-ТӨА	Байгууллагын дотоод журмыг зөрчиж, нэр бүхий 4 ажилтанд 9.7 сая төгрөгийн сургалтын төлбөр олгосон.	Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн	1	9,700.0					1	9,700.0				
7	Хөдөө аж ахуйн бирж ХХК	АХГ-2022/80/НА-СТА-ТӨА	Гүйцэтгэх захирлын 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн "Албан тушаалын жагсаалт шинэчлэн батлах тухай" А/30 дугаар тушаалаар баталсан орон тооны хязгаараас илүү 3 ажилтантай хөлсөөр ажиллvулах гэрээ	Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн	1	9,640.0					1	9,640.0				

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

			байгуулж, цалингийн зардал зарцуулсан.													
8	Хөдөө аж ахуйн бирж ХХК	АХГ-2022/80/НА-СТА-ТӨА	Тайлант оны байгууллагын худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаагүй тавилга хэрэгсэлийн худалдан авалт хийсэн байна.	Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн	1	15,308.4					1	15,308.4				
9	Хөдөө аж ахуйн бирж ХХК	АХГ-2022/80/НА-СТА-ТӨА	Буруутай албан тушаалтны шийдвэрийн улмаас ажлаас халагдсан ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн төлбөрийг байгууллагаас төлж, авлагаар тусгасныг барагдуулаагүй.	Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн	1	16,417.9					1	16,417.9				
10	Хөдөө аж ахуйн бирж ХХК	АХГ-2022/80/НА-СТА-ТӨА	Малчдад төлөх ноолуурын өрийн үлдэгдлийг ТУЗ-ийн шийдвэрээр "Наранзолбоот кашмер" ХХК-ийн өмнөөс төлж, 3 сарын хугацаатай эзэлийн гэрээ байгуулсан боловч хугацаандаа төлөөгүйгээс хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэл байна.	Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн	1	731,456.5					1	731,456.5				
11	Хөдөө аж ахуйн бирж ХХК	АХГ-2022/80/НА-СТА-ТӨА	Тус байгууллагын ложистикийн төвийн барилга, угсралтын ажлын үлдэгдэл төлбөр өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна	Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах зөвлөмж өгсөн	1	76,185.0									1	76,185.0
12	Хөдөө аж ахуйн бирж ХХК	АХГ-2022/80/НА-СТА-ТӨА	Байгууллагын үйл ажиллагаанд худалдан авсан бараа материалд 0.3 сая төгрөгийн хувь иргэнд олгосон цахим төлбөрийн баримт бүрдүүлсэн байна.	Бараа материал худалдан авах, ажил үйлчилгээний төлбөрийг цахим баримтаар баталгаажуулж ажиллах өвлөмж өгсөн	1	296.0									1	296.0
ДҮН					12	933,039.9	5	74,036.1			5	782,522.8			2	76,481.0
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Хөдөө аж ахуйн бирж ХХК	АХГ-2022/80/НА-СТА-ТӨА	Шилэн дансны цахим системд мэдээллээ хугацаанд нь байршуулах албан шаардлага өгснийг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд 7,514,733.0 мянган төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн							1					
ДҮН					1											
НИЙТ ДҮН					13	933,039.9	5	74,036.1			6	772,822.8			2	76,481.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 334 / А0150458

Улаанбаатар хот

АХГ-2022/80/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ Үүнд:

Тайлант онд нийт 163 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх" гэсэн заалттай нийцээгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг ил тод, хугацаанд нь байршуулж байх, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн захирал О.Нарандэлгэр, нягтлан бодогч Б.Номин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 335/А0150458

Улаанбаатар хот

АХГ-2022-80/НА-СТА-ТБА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компани нь байгууллагын дотоод журмыг зөрчиж, нэр бүхий 4 ажилтанд 9,700,000.00 төгрөгийн сургалтын төлбөр олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь үйлдүүлэн, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.19 "Ажилтны орон сууцны судалгааг төрөлжүүлэн гаргаж, түүнд үндэслэн орон сууц, хашаа байшин худалдах авах, шинээр барих, нөхцөлийг нь сайжруулахад хууль тогтоомжийн дагуу банкны урт хугацаат хөнгөлөлттэй зээлд хамруулах, зохих санхүүгийн дэмжлэг, тусалцаа үзүүлэх бодлого баримталж, тухайн жилийн төсөвт тусгаж өгнө" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн захирал О.Нарандэлгэр, нягтлан бодогч Б.Номин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-15.Docx

00108C0985



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 336/АД150458

Улаанбаатар хот

АХГ-2022/80/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн "Албан тушаалын жагсаалт шинэчлэн батлах тухай" А/30 дугаар тушаалаар баталсан орон тооны хязгаараас илүү 3 ажилтантай хөлсөөр ажиллуулах гэрээ байгуулж, 9,600,000.00 төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байх" гэсэн заалттай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн захирал О.Нарандэлгэр, нягтлан бодогч Б.Номин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

(Signature)
(Signature)
(Signature)

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ

00108C0987



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 334/40150458

Улаанбаатар хот

АХГ-2022/80/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ Үүнд:

Малчид, бэлтгэн нийлүүлэгчдийг дэмжих зорилгоор малчдад төлөх ноолуурын өрийн үлдэгдлийг ТУЗ-ийн шийдвэрээр Наранзолбоот кашмер ХХК-ийн өмнөөс төлж, уг компанитай 2021оны 5 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай зээлийн гэрээ байгуулсан боловч зээлийн төлбөрийг хугацаандаа төлөөгүйгээс 731,456,500.00 төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулж, дээрх зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн захирал О.Нарандэлгэр, нягтлан бодогч Б.Номин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засагын газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-19.Docx

0010800993



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 339/А0150458

Улаанбаатар хот

АХГ - 2022/80/НА - СТА - ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ Үүнд:

Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 16,417,935.00 төгрөгийг байгууллагаас төлж, авлагаар тусгасныг барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 "Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүйгээр халагдсан ажилтанд олгосон 16,417,935.00 /Арван зургаан сая дөрвөн зуун арван долоон мянга есөн зуун гучин таван/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Алтансүхэд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ

00108C0991

[illegible]